



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 33 (414)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны есдүгээр сарын 7

№33 (414)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

927.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 34	705
	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр		706

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 8 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Сонгогчдын болон Монгол Улсын Засгийн газрын саналыг тусган боловсруулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга /Т.Билэгт/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

2005-2009 он

Хөгжлийн төлөө зүтгэл Хүний төлөө сэлтэл

Монгол Улсын хөгжлийн шинэ үе шатанд тулгараад буй улсынхаа эдийн засгийн чадамж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх; засаг төрийнхөө ардчилсан, харууцлагатай, хяналттай үйл ажиллагааг бэхжүүлэх; нийгмээ ажиглүүдэл, ядуурал, хүнд суртал, авилга, хээл хахууль, шударга бус явдлаас ангижруулах; иргэдээ эрүүл, аюулгүй орчинд аж төрж, өндөр боловсрол эзэмшиж, чинээлэг хангалуун, тайван амьдрах боломжоор хангах түүхэн зорилгыг ард түмнийхээ хамт хэрэгжүүлэх Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн агуулга нь:

- *Иргэний эрх, эрх чөлөө, ирээдийн бүх талын оролцоо, харууцлагатай төрийн байгууламжуудын хууль ёсны*

шүтлэгтэй эрх, эрх чөлөө, ирээдийн бүх талын оролцоо, харууцлагатай төрийн байгууламжуудын хууль ёсны

шүтлэгтэй эрх, эрх чөлөө, ирээдийн бүх талын оролцоо, харууцлагатай төрийн байгууламжуудын хууль ёсны

хэм хэмжээг хосолсон соёлтой бизнес, хөгжлийн суурь бүтээн байгуулалтыг дэмжихэд оршино.

Үйл ажиллагааны энэ хөтөлбөрт Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр иргэдээс ирүүлсэн саналуудыг тусгасан болно.

№	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтууд	Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэлбэр	Хугацаа	Хариуцах байгууллага
Нэг Үндэсний эв нэгдлийг эрхэмлэн, төрийн байгууллын тогтолцооны тэнцвэртэй, хяналттай байдлыг хангах				
1.1	Үндэсний эв нэгдлийг бататган бэхжүүлэх үйлсэд улс үндэстнийхээ түүх, соёлын уламжлал, ардчиллын байгууламжуудын хүчин чадлыг дүүрэн ашиглаж, нийгмийн шударга ёсны төлөвшилд ёс суртахууны үлгэр үзүүлэх	1.1.1. Үндэсний хөгжлийн цөцг бодлого бий болгох ажлыг ивээлдээ аен боловсруулна. 1.1.2. Ард түмэнд хандсан үг хэлэх, илгээлт гаргана 1.1.3. Түүхэн уламжлал, ёс заншилны зөвлөлийг шинэчлэн ажиллуулна. 1.1.4. Нийгмийн бүх хүрээнд шударга ёсны хэм хэмжээг төлөвшүүлэхэд онцгой анхаарч ажиллана.	2005-2009 2005-2009	ЕТГ
1.2	Төрийн байгууллын тогтолцооны тэнцвэртэй, хяналттай байдлыг хангаж, санаачилгатай, уян хатан байх зарчим баримтатана	1.2.1. Ерөнхийлөгч УИХ-тай харилцах эрх зүйн бүх боломжийг хэрэгжүүлж ажиллана. 1.2.2. Засгийн газрын бүтээлч, үр дүнтэй үйл ажиллагааг дэмжихийн хамт, тодорхой асуудлаар санал чиглэл өгнө.	2005-2009	ЕТГ

<p>1.3 Засаг төрийн байгууллагууд хууль дээдлэх, ардчилсан зарчмыг баримтлан үр ашигтай, шуурхай, харууцлагатай ажиллах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, ардчилсан төрийн хууль хэрэгжүүлдэг байх орчин нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн шуарга ёсыг төлөвшүүлэх, ард түмний амгаланг тайван аж төрөх нөхцлийг ханган ажиллах</p>	<p>1.3.1. Иргэний нийгмийн зүй зохистой оролцоог хангах замаар төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд мониторинг хийж, ажлын чиглэл, зөвлөмж өгнө.</p> <p>1.3.2. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль саналачилна.</p> <p>1.3.3. Монгол Улсад мөрдөгдөж буй хуулиуд тэдгээрийн хэрэгжилтийн эрх зүйн шинэглэлийн хөтөлбөрийн талаар ХЗДХ-ийн сайдын мэдээллийг сонсоно.</p> <p>1.3.4. Иргэдийн амьд явах эрх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах Үндсэн хуулийн эрхийн хэрэгжилтийн байдлаар мэдээлэл сонсоно.</p>	<p>Жил бүр 2006-2007</p> <p>2005</p> <p>2006</p> <p>2006</p> <p>2006</p>	<p>ЕТГ ХЗДХЯ</p> <p>ЕТГ ЗГХЭГ</p> <p>ЕТГ, ХЗДХЯ</p> <p>ЕТГ, ЦЕГ, ХЗҮК БОЯ УМХГ</p> <p>Засгийн газар ЕТГ, ТАЗ</p>
<p>1.4 Төрийн бүх шатны байгууллага, албан хаагчдыг хамарсан харууцлагын тогтолцоог боловсронгуй болгож төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх, төрийн үйлчилгээний хөнгөн шуурхай байдлыг хангах талаар ажиллана</p>	<p>1.4.1. ТАЗ-ийн дэргэн мэдээлэл сонсож, чиглэл өгнө.</p> <p>1.4.2. Эрдэм шинжилгээний болон ТББ-ын зүй зохистой оролцоотойгоор төрийн албан хаагчдын ёс зүйн байдлаар судалгаа хийж холбогдох арга хэмжээ авна.</p> <p>1.4.3. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл саналчлан боловсруулна.</p>	<p>2007</p> <p>Жил бүр</p> <p>2005-2009</p> <p>2005-2009</p> <p>Жил бүр</p> <p>2005-2009</p> <p>2005-2009</p>	<p>ЕТГ</p> <p>Улс төрийн намууд</p> <p>ТББ-ууд</p>
<p>1.5 Монголын нийгмийн улс төрийн тогтолцоог төгөлдөржүүлэх, нийгмийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эх орныхоо хөгжлийн таатай орчин бүрдүүлэх үүднээс улс төрийн нам, хүчин, төрийн болон төрийн бус байгууллагуудын зарчим, бүтээлч хамтын ажиллагааг бүх талаар дэмжих.</p>	<p>1.5.1. Улс төрийн намуудын удирдлагатай хийх уулаалт, яриат тогтмолжуулна.</p> <p>1.5.2. Төмөрхөн үйл явдал, ойг тохиолдуулан үг хэлэх, мөндчилгээ явуулах.</p> <p>1.5.3. Улс төрийн тогтолцоог төгөлдөржүүлэх санал саналачилгыг дэмжиж онол практикийн бага хурал зохион байгуулна.</p> <p>1.5.4. Төрийн бус байгууллагуудаас нийгмийн тогтвортой байдал, улс орны хөгжилд дөрөвтэй хувь нэмэр оруулж буй 3 хүртэл байгууллагыг жил бүр шалгаруулж Ерөнхийлөгчийн нэрэмжит өргөмжлөл гардуулна.</p> <p>1.5.5. Төрийн байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ТББ-ын үйл ажиллагааг онцгойлон дэмжих бодлого баримтална.</p>	<p>Жил бүр</p> <p>2005-2009</p> <p>2005-2009</p>	<p>ЕТГ</p> <p>Улс төрийн намууд</p> <p>ТББ-ууд</p>

1.5	Монгол орны нийгмийн баялгийг гэрцэн бүтээж байгуулагч гол хүч болсон жирийн малчин, тариалан, ажлынчлон олон түмнийхээ хөдөлмөр зүтгэлийг төрөөс үнэлж, урамшуулах механизмийг боловсронгуй болгох.	1.6.1. Урамшуулал, дэмжлэгийн олон хэлбэрийг бий болгоно. 1.6.2. Хөдөлмөр зүтгэлээрээ амжилт гаргасан хүмүүсийн судалгаа, сурталчилгааг сайжруулах.	2005-2009 2005-2009	ETГ Яамдууд
Хоёр Эдийн засгийн осолтийг бататгаж, чадавхийг бэхжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх				
2.1	Макро эдийн засаг, нийгмийн гол үзүүлэлтүүдийн тэнцвэрт харьцааг сайжруулах.	2.1.1. 2006-2009 оны Монгол Улсын төсөв, үндсэн чиглэл, мөнгөний бодлогын асуудлаар УИХ-ын чуулганд өөрийн байр суурь, санал бодлоо илэрхийлнэ. 2.1.2. Эдийн засгийн шинэчлэлийг хурдасгах, бүтцийг зохистой болгох болон бусад холбогдох асуудлаар Засгийн газарт чиглэл өгнө. Засгийн газрын хуралдаанд оролцож бодлого, байр сууриа илэрхийлж байна.	Жил бүрийн 9-10 сард 2005-2009	ETГ Засгийн газар
2.2	Үндэсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, жижиг, дунд бизнесийг дэмжих банк, санхүүгийн үйлчилгээг сайжруулах замаар олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах үндсэн дээр эдийн засгийн тогтвортой өндөр осолтийг хангах бодлогыг төр, засгийн бодлогын анхаарлын төвд байлгах.	2.2.1. Экспортын чиглэлээр, шинэ технологи нэвтрүүлэн амжилтаж буй зарим үйлдвэр, аж ахуйн газрын ажилтай танилцаж зөвлөлтөө өгнө. 2.2.2. Сангийн яам, Үйлдвэр, худалдааны яам болон Монгол банкны удирдлагатай туулаж чиглэл өгнө. 2.2.3. Шинэ бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ бий болгож, дэвшилтэт технологи нэвтрүүлэн, чанар болон өрсөлдөх чадвараа өсгөж байгаа үйлдвэр, аж ахуйн газарт Ерөнхийлөгчийн нэрэмжит "Үндэсний бүтээмжийн шагнал" олгоно.	Жил бүр 2006 2008 Жил бүр	ETГ СЯ УХЯ МБ ХАУТ Орон нутаг
		2.2.4. Томоохон хөрөнгө оруулалттай зарим уул уурхайн үйлдвэрийн ажил байдалтай танилцаж цаашдын хөгжлийн асуудлаар Засгийн газарт санал хүргүүлнэ.	2007	

2.3	Байгаль цаг уурын нөхцлөөс бага хамаралтай, өндөр үр ашгтай, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн фермерүүдийг бий болгох, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	2.3.1. Эрчимжсэн МАА, газар тариаланг хөгжүүлэх тухай хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилт, байдалтай танилцаж Засгийн газарт чиглэл өгнө. 2.3.2. Өндөр үр ашгтай мал аж ахуйн төрөлжсөн дагнасан фермерүүдийг жил бүр шалгаруулах тухай чиглэл Засгийн газарт өгнө. 2.3.3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд чиглэсэн бодлого үйл ажиллагааг дэмжинэ. 2.3.4. Жил бүр экологийн цэвэр бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, шалгаруулалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах чиглэл өгнө. 2.3.5. Засгийн газрын усны бодлогын хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж чиглэл өгнө.	2007 Жил бүр Байнга Жил бүр 2007	ЕТГ ЗГХЭГ ХХААЯ ХАУТ
2.4	Гамшгаас сэргэжлүүлэх, гамшгийн болон түүний дараа үед шуурхай амжиллах чадвархийг бүрдүүлэхэд холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах.	2.4.1. Онцгой байдлын сайдыг хүлээн авч уулзан, ажил байдалтай нь танилцаж, чиглэл өгнө. 2.4.2. Улсын нөөц, түүний ашиглалтын байдалтай танилцаж, Засгийн газарт чиглэл өгнө. 2.4.3. Гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, хойшуулушгүй сөргөн босгох арга хэмжээнд оролцох цэргийн анги, салбаруудын үүрэг гүйцэтгэх боломж, чадавхийг нэмэгдүүлнэ. 2.4.4. Ган зудны уршгийг арилгах, малчдыг малжуулах төслийн хэрэгжилттэй танилцаж чиглэл өгнө.	2005-2009 2006 2005-2007 2005-2007	ЕТГ ОБЕГ БОЯ БХЯ

2.5	Монгол Улсын иргэд газраа өмчлөн эдийн засгийн эргэлтэнд идэвхтэй оруулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох.	2.5.1. Газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлын явц, эрх зүйн орчны байдал, бусад холбогдох асуудлаар Газрын харилцаа, геодээ зурга зүйн газрын удирдлагыг хүлээн авч уулзаж, чиглэл өгнө. 2.5.2. Газар тариалангийн гол бүс нутагт хувьчлалын ажлыг хэрхэн зохион байгуулж, авч хэрэгжүүлж байгаа ажлын явц ямар байгаа талаар тухайн аймгуудын удирдлагыг хүлээн авч уулзаж зөвлөмж чиглэл өгнө. 2.5.3. Газар тариалангийн үйлдвэрлэл, намрын ургац хураалтын ажилтай танилцаж зөвлөлтөө өгнө. 2.5.4. Газар өмчлөл, газрын харилцааг боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана. 2.5.5. Монгол Улсын Засгийн газартай хамтарч бэлчээрийг зохицой ашиглах асуудлаар зөвлөмж чиглэл боловсруулан гаргаж аймаг, орон нутгийн удирдлагуудад зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэг өгнө.	2005 2006 2005-2009 2005-2009	ЕТГ БХБЯ ГХГЗЭГ ХХААЯ
2.6	Гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хотолбор, төслүүдийг дэмжих.	2.6.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар тус улсад гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулж, уг чуулганд оролцогчлод хандаж байр сууриа илэрхийлэн үг хэлнэ. 2.6.2. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоодын хөрөнгө оруулалтыг урамшуулахад чиглэгдсэн шинэ хотолбор, төслүүдийг санаачлан боловсруулах, гааль, татварын бодлогоор дэмжих чиглэлийг Засгийн газарт өгч хамтран ажиллана.	2007 2006	ЕТГ УХЯ ГХОГ УТЕГ УТЕГ
Гурав. Мэдлэг, мэдээлэл, шинэ технологи, оюуны соёлыг улс орны хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйл болгох				
3.1	Дэлхийн жишигт нийцсэн боловсролын тогтолцоо, стандартыг нэвтрүүлэх, орчин цагийн шинэчлэх ухааны өндөр мэдлэг, мэдээллийн шинэ технологи эзэмшсэн, чадвартай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.	3.1.1. Бүх шатны төрийн бус өмчийн сургуулийн тухай хуулийн төсөл боловсруулна. 3.1.2. "Иргэний боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор боловсруулна.	2007 2005-2006	ЕТГ БСШУЯ ЕТГ БСШУЯ

	<p>3.1.3. Гадаад, дотоодын хандивлагчдын санаачилгыг дэмжих замаар альвас, сурлага сайтай боловч сургалтын төлбөрийн чадваргүй хүүхэд, залуусыг их, дээд болон мэргэжлийн сургуульд суралцуулах "Ерөнхийлөгчийн сан" байгуулах хөдөлгөөнийг дэмжих.</p> <p>3.1.4. Ерөнхий боловсролын сургуульд үндэсний түүх, соёл, зан заншил, эх орон, үндэсний бахархлыг төлөвшүүлэх чиглэлээр заавч хичээлийн агуулгыг баяжуулах, санаачилгыг дэмжих.</p> <p>3.1.5. Боловсролын шинэ стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, дэлхийн жишгтэй дүйцэх боловсролын тогтолцоо бий болгох бодлого барьж, загвар сургууль бий болгоход үйл ажиллагаагаа чиглүүлнэ.</p> <p>3.1.6. "Шилдэг сурах бичиг" туурвигчдад Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгоно.</p> <p>3.2.1. Шинжлэх ухаанд улсын төсвөөс зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх талаар Улсын Их Хурал, Засгийн газарт санал тавина.</p> <p>3.2.2. Монголын түүх, соёл, археологийн олон улсын судалгааны төслүүдийг ивээлдээ авч, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>3.2.3. Шинжлэх ухаан технологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, инновацын парк байгуулах талаар Засгийн газарт чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавина.</p> <p>3.2.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулсан Олон улсын монголч эрдэмтдийн их хурлыг хуралдуулна.</p> <p>3.2.5. Монголын үндэсний нэгтэрхий толь, Монголын үндэсний атлас зэрэг эрдмийн томоохон суурь бүтээлүүдийг шинэчлэн туурвих ажлыг санаачилна.</p> <p>3.2.6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит "Шилдэг залуу эрдэмтэн", "Шилдэг залуу монгол судлаач эрдэмтэн"-ий шагналыг олгоно.</p> <p>3.2.7. "Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн хамгааллын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ" хэлэлцүүлэг зохион байгуулна.</p>	<p>2006-2009</p> <p>2005-2009</p> <p>2005-2009</p> <p>Тогтмол 2006</p> <p>2005-2009</p> <p>2005</p> <p>2006</p> <p>2005-2009</p> <p>Жил бүр</p> <p>2006</p>	<p>ЕТ СЯ БСШУЯ</p> <p>ЕТ БСШУЯ ШУА</p> <p>ЕТ ШУА</p> <p>ЕТ БСШУЯ ШУА</p> <p>ШУА ЕТ</p> <p>ЕТ Оюуны өмчийн газар</p> <p>ЕТ НХХЯ ШУА</p>
<p>3.2 Үндэсний шинжлэх ухааны чадамжийг бэхжүүлэн Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийг улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой өсөлтийн тулгуур хүчин зүйл болгох, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдэд түлхүү анхаарах.</p>			

МХХТГ	2005	2005-2009	2006
<p>3.3 Мэдээлэл харилцааны орчин үеийн технологийг төрийн үйлчилгээ, үйлдвэрлэл, худалдаа, аялал жуулчлалын салбарт эрчимтэй нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.</p>	<p>3.3.1.Мэдээлэл харилцаа холбоо, технологийн газрын даргын мэдээллийг сонсож, чиглэл өгнө.</p> <p>3.3.2.Засгийн газрын "Цахим Монгол" хөтөлбөрийн хэрэгжилт, явц байдалтай танилцана.</p>	<p>3.4.1. Бүсийн төвүүдэд урлаг, соёлын төв байгуулахыг дэмжиж хүүхэд залуучуудад сонгодог урлагийн боловсрол олгоход түлхүү анхаарна.</p> <p>3.4.2. Сонгодог урлагийн нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд анхаарч олон улсын сонгодог урлагийн уралдаан тэмцээнд уран бүтээгчдээс оролцуулахыг дэмжиж, монголын сонгодог урлагийн хөгжлийг сурталчлах арга хэмжээ авна.</p>	<p>2005-2009</p> <p>2006</p>
<p>3.4 Оюуны соёлын хүрээнд бүтээлч сэтгэлгээ, чөлөөт өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр соёл, урлагийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, энэ салбар зах зээлийн харилцааны нийтлэг жишгээр хөгжих нөхцлийг бүрдүүлэн төрийн дэмжлэг, зохицуулалтыг оновчтой болгоход анхаарах.</p>	<p>3.4.3. Монголын үндэсний уламжлалт урлаг бодит ба бодит бус соёлын өвийг бүртгэх уламжлалыг хадгалах, сэргээн хөгжүүлэх санал санаачлагыг бүх талаар дэмжинэ.</p> <p>3.4.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Монгол туургатны урлагийн их наадам, дэлхийн монголчуудын чуулга уулзалт" зохион байгуулна.</p> <p>3.4.5.Мөрин хуурын шилдэг бүтээл, сонгодог урлагийн бүтээлд Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгоно.</p> <p>3.4.6.Урлаг соёл, оюуны шилдэг бүтээлүүдийг жил бүр тодруулж төрийн шагнал олгоно.</p> <p>3.4.7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Дэлхийн яруу найрагчдын 26 дугаар их хурлыг зохион байгуулна.</p>	<p>2005-2009</p> <p>2006</p> <p>2005-2009</p> <p>Жил бүр</p> <p>2006</p>	<p>ЕТГ БШУЯ</p> <p>ЕТГ. Засгийн газар</p> <p>ЕТГ Соёлын сан</p>

Доров. Эх оронч үзлийг төлөвшүүлэх

4.1.	<p>Эх оронч үзэл, үндэсний бахархлыг нийгмийг нягтруулагч, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэгч суурь үзэл санаа болгон хөгжүүлэх.</p>	<p>4.1.1.Их Монгол Улсын 800 жилийн ойг үндэсний бахархлын баяр ёслол болгох ажлыг Ерөнхийлөгчийн ивээлд авч Засгийн газарт чиглэл өгч ажиллана.</p> <p>4.1.2.Эх оронч үзэл төлөвшүүлэх Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилттэй танилцаж Монгол тэмүүллийг бий болгон энэ чиглэлээр иргэний нийгэм хэвлэл мэдээллийн байгууллагуудаас гаргаж байгаа эерэг санаачилгыг дэмжинэ.</p> <p>4.1.3. Үндэсний түүх, соёл, ёс уламжлал, зан заншлын асуудлаар Ерөнхийлөгчийн ивээл дор улирал тутмын "Манай монгол" сэтгүүлийг эрхлэн гаргана.</p>	<p>2005-2006</p> <p>2006</p> <p>Улирал тутам</p>	<p>ЕТГ БСШУЯ</p>
4.2.	<p>Үндэсний соёл, урлаг, спортын эрхэм өв, ариун нандин уламжлалаа баяжуулан хөгжүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн олон нийтийн хөдөлгөөнийг улам зрчимжүүлэхэд анхаарах.</p>	<p>4.2.1. Бүсийн төвүүдэд спортын цогцолбор барих ажлыг дэмжинэ.</p> <p>4.2.2. Хүн амд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлж, нийтийн биеийн тамир хөгжүүлэх ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгох иргэд, байгууллагын санал, санаачилгыг дэмжиж ажиллана.</p> <p>4.2.3. Зуны олимпын төрөлд амжилт үзүүлэх бололцоотой спортын төрлүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхаарлын төвд байлгаж, Олимпын цогцолборыг барьж дуусгах ажлыг дэмжинэ.</p> <p>Зуны олимпын ХХІХ наадамд амжилттай оролцох талаар нийт иргэдэд хандсан уриалга гаргаж, олимпод оролцох тамирчдын бэлтгэлийг сайтар хангахад анхаарна.</p> <p>4.2.4. 2012 онд Лондон хотноо болох зуны олимпын ХХХ наадамд амжилттай оролцох талаар Засгийн газрын анхаарлыг чиглүүлнэ.</p>	<p>2006-2007</p> <p>2006-2009</p> <p>2006</p> <p>2007</p> <p>2009</p>	<p>ЭМЯ БТСУХ МУОХ</p> <p>ЭМЯ</p> <p>МУОХ</p> <p>ЭМЯ БТСУХ МУОХ</p>

Тгв. Суурь бүтээн байгуулалт, дэд бүтэц, аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх				
5.1	"Манганы зам", "Эрчим хүчний нэгдсэн сүлжээ", мэдээлэл, харилцаа холбооны хөтөлбөр зэрэг суурь бүтээн байгуулалтуудыг үргэлжлүүлэн, тэдгээрийн үр өгөөжийг нийгэм, олон түмэнд бодитой хүргэх.	5.1.1. "Манганы зам"-ын босоо тэнхлэгийн замуудын бүтээн байгуулалтын ажилтай танилцаж олон улсын байгууллагын тусламжийг авах чиглэлээр ажиллана.	2005-2009	ЕТГ БХБЯ ТЭХЯ
		5.1.2. "Эрчим хүчний нэгдсэн сүлжээ", хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.	2006-2009	
		5.1.3. Харилцаа холбооны суурь үйлчилгээг өргөжүүлэхэд зээл тусламж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана.	2008	
		5.2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлого, өнөөгийн тулгамдсан асуудлууд, цаашдын хандлага" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулна.	2007	
5.2	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд бүсийн тулгуур төвүүд, аймгийн төв, сум суурин газруудыг холбосон болон дотоод дэд бүтцийг хөгжүүлэх, хот суурин газрыг барилгажуулах, тохижуулах бодлого, үйл ажиллагааг дэмжих.	5.2.2. Бүсийн тулгуур төвүүдийг барьж байгуулах ажилтай танилцаж бус нутгийн цаашдын хөгжлийн асуудлаар үг хэлж санаа бодлоо солилцоно.	2005-2009	ЕТГ
		5.2.3. Бүсийн төвүүдэд томилолтоор ажиллаж барилга угсралт, барилтын материалын үйлдвэрлэлийн болон орон сууцны барилга угсралт, хот тохижуулалтын ажилтай танилцаж аймаг орон нутгийн удирдлагуудад зөвлөмж өгнө.	2008-2009	
		5.2.4. Салаа төмөр замыг байгуулах талаар Засгийн газарт чиглэл өгч хянаж ажиллана.	2005-2009	

5.3	Нар, салхи, ус зэрэг сэргээгдэх эрчим хүч ашиглах замаар хөдөөгийн сум суурин, малчин айд өрхийг эрчим хүчээр хангах хүрээг өргөжүүлнэ.	5.3.1 Хөдөөгийн сум, суурин, малчин айд өрхийг нар, салхины сэргээгдэх эрчим хүчээр хангах Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих ажиглана. 5.3.2 Тайшвр, Дөргөний усан цахилгаан станцуудын барилгын ажлын явцтай танилцаж, хугацаанд нь ашиглалтанд оруулах талаар анхаарна.	2005-2009 2006-2009	ETГ ТЭХЯ
5.4	Том хот, суурин газруудад утаагүй түлш хийн түлш ашиглах зэргээр утаа, тоосгүй орчин бий болгох сумын төв, суурин газрыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн учрыг усаар хангахад Засгийн газрын үйл ажиллагааг чиглүүлнэ.	5.4.1 Нийслэл хотын агаарын бохирдлыг эн тэргүүнд эрчлэх, утаагүй түлш хийн түлш өргөнөөр ашиглах боломжийг бүрдүүлэх чиглэл, зөвлөмж өгч хэрэгжилтийг дэмжин ажиглана. 5.4.2 Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн учныг усаар хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлийг Засгийн газар, холбогдох аймаг сумдын удирдлагуудад өгнө	2006 2007	ETГ ТЭХЯ БОЯ ETГ
5.5	Агаарын тээврийн үйлчилгээг өргөжүүлж, түүнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, орон нутгийн нислэгийн зориулалт бүхий онгоцны парк шинэчлэхэд гадаадын хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	5.5.1 Монголын агаарын тээврийн салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх өрсөлдөөнийг дэмжиж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах талаар анхаарна.	2005-2009	ETГ ЗТАХЯ
5.6	Алгал жуулчлалын гол бүс нутгуудад жуулчлалын цогцолбор байгуулах, дэд бүтцийг өргөтгөх үндсэн дээр алгал жуулчлалын олон төрлийг хөгжүүлж, дотоодын алгал жуулчлалыг дэмжинэ.	5.6.1 Жуулчны улирлыг уртасгах, жуулчлалыг хөгжүүлэх, алгал жуулчлалын байгууллагын нийлүүлж байгаа бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжинэ. 5.6.2 Ерөнхийлөгчийн нээл дор "Алгал жуулчлал эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжийн Удирдах Ажилтнуудын улсын эвэллөгчөөн"-ийг зохион байгуулна. 5.6.3 Алгал жуулчлалын эзэндэвэр гаргах аяллыг дэмжиж Ерөнхийлөгчийн оролцоотой хийгдэх төрийн ёслолын үйл ажиллагаануудыг тусгах	2005-2009 2008 2005-2009	ETГ ЗТАХЯ ETГ

Зургаа. Иргэд, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажиглүйдэл, ядууралтай тэмцэх, шударга чинээлэг нийгмийг төлөвшүүлэх

6.1	<p>Монголын эдийн засгийн өсөлтийн өнөөгийн түвшинг хадгалах бодлогыг Засгийн газарт чиглэл өгч, эдийн засгийн өсөлтөөс олсон үндэсний орлогын 50 хувийг жил бүр улс орныхоо нийгмийн салбарт зарцуулж, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд шууд зарцуулах журам тогтоох хуулийн төслийг санаачлан УИХ-аар батлуулан мөрдөх ажлыг эн тэрүүнд хэрэгжүүлнэ.</p>	<p>6.1.1. Эдийн засгийн өсөлтөөс олсон үндэсний орлогын 50 доошгүй хувийг нийгмийн салбарт зарцуулах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.</p> <p>6.1.2. "Монгол Улсын Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого"-той танилцаж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авна</p>	<p>2006</p> <p>2007</p>	<p>ЕТГ НХХЯ</p>
6.2	<p>Хүн амын орлогыг нэмэгдүүлэх, өрхийн амьжиргааг дэмжих, ахлын байр бий болгох, сургалт-үйлдэргэлийн нөдгөлд хангах, мэргэжлийн сургалтыг өргөтгөхөд Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого, хэрэгжүүлэх буй үйл ажиллагааг чыгтүүлж, дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>6.2.1. Мөнгөний хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ахлын талаар Засгийн газрын мэдээллийг сонсож, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газарт синал оруулна.</p> <p>6.2.2. Орон сууц барих, залуу гэр бүлийг дэмжих, хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулахад анхаарна.</p> <p>6.2.3. Ахлын байр шинээр бий болгож буй аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр хуулийн төсөл боловсруулна.</p> <p>6.2.4. Бүсийн төвүүдэд мэргэжлийн сургалт-үйлдэргэлийн цогцолбор сургууль байгуулахыг дэмжинэ.</p>	<p>2005-2006</p> <p>2005-2009</p> <p>2007</p> <p>2005-2009</p>	<p>ЕТГ, ЗГ</p> <p>ЕТГ, НХХЯ</p> <p>ЕТГ, СЯ, НХХЯ</p>
6.3	<p>Үндэсний үйлдвэрлэлчид, жижиг бизнес эрхлэгчид, иргэд, малчид, тариаланчдын байгуулсан хоршоо, нөхөрлөлийг дара хууль эзэллээр дэмжих замаар ахлын байраа тогтвортой хадгалах, орлогоо нэмэгдүүлэх боломжийг өргөтгөхөд анхаарна.</p>	<p>6.3.1. Татварын болон зээлийн уян хатан бодлогоор жижиг дунд бизнес эрхлэх талтай орчинг бүрдүүлэх чиглэлээр амжилта.</p> <p>6.3.2. "Эзэн хичээлээ зан хичээл" уриан дор айл өрх бүр орлогоо нэмэгдүүлэх хөдөлгөөн өрнүүлж ТББ-тай хамтран ажиллана.</p>	<p>2005-2009</p> <p>Жил бүр</p>	<p>ЕТГ Засгийн газар</p> <p>ЕТГ Засгийн газар</p>
6.4	<p>Нийгмийн халамжийн үйлчилгээний төвлөрлийг сааруулж, нийгмийн эмзэг хэсэгт зориулан Төрөөс олгох байгаа хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, энэ үндсэн дээр нэн ядуу, ядуу айл өрхийн амьжиргааг тууштай дээшлүүлэхийг зоринэ.</p>	<p>6.4.1. Төр, засгийн үйл ажиллагааг дүгнэхдээ ядуурлыг бууруулах, ахлын байр бий болгосноор дүгнэх тогтоолоог бий болгоно.</p> <p>6.4.2. Хөгжлийн борхисалтай иргэдийн талаар Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээтэй газар дээр нь танилцаж, үүрэг даалгавар өгнө.</p>	<p>2007</p> <p>2006</p>	<p>ЕТГ НХХЯ</p>

6.5	Эрүүл мэндийн даатгалын бие даасан байдлыг хангаж, даатгалтай иргэнд үзүүлэх урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.	2005-2009 2007	ЕТГ НХХЯ ЭМЯ
6.5.1.	Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох эрх зүйн орчин бүрдүүлэхэд анхаарна.	2005-2006	ЕТГ ЭМЯ
6.5.2.	Даатгалтай иргэдэд үзүүлэх урамшууллын талаар Даатгалын тухай болон холбогдох хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл санаачилна.	2006-2009	ЕТГ НХХЯ ЭМЯ
6.5.3.	"Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын хэрэгжилттэй танилцаж, Засгийн газарт санал оруулна.	2008-2009	ЕТГ ЭМЯ
6.5.4.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит "Шилдэг залуу эмч" -ийн шагналыг олгоно.		
6.5.5.	Өвчтөний эрх ашгийг хамгаалах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар гарсан санаачилгыг дэмжих		
6.6	Иргэдийн эрүүл ахуйн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарч, хүний эрүүл мэндийн "32 цагаан мянаач" болсон шүдийг эрүүлжүүлэх Ерөнхийлөгчийн тусгай Хөтөлбөрийг санаачлан ивээлдээ авч хэрэгжүүлнэ.	2006	ЕТГ ЭМЯ
6.6.1.	Ажлын хэсэг байгуулж хөтөлбөр боловсруулж Засгийн газарт чиглэл өгнө.	2006	ЕТГ ЭМЯ
6.7	Нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгон үйлчилгээний чанар, хүртээмжийг нь нэмэгдүүлж, нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн хангамж үйлчилгээг сайжруулна.	2006	ЕТГ НХХЯ УНДЕГ
6.7.1.	Нийгмийн даатгалын сангуудын бие даасан байдлыг хангах талаар Засгийн газарт санал оруулна	2006	ЕТГ НХХЯ
6.7.2.	Нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох замаар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулах хуулийн төсөл боловсруулна	2006	ЕТГ НХХЯ
6.7.3.	Цэргийн албан хаагчдыг нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах, цэргийн албыг биечлэн хаасан иргэдэд төрөөс халамж үзүүлэх зэрэг цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг санаачилж хэрэгжүүлнэ	2005-2009	ЕТГ НХХЯ БХЯ

6.8	Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн төлөө идэр насандаа амь, бие, мэдлэг оюун, хүч хөдөлмөрөө үл хайрлан тэмцэж, бүтээн байгуулж ирсэн ахмад үеийнхнийхээ нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлого, үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээлд авна.	6.8.1. 1995 оноос өмнө, хойно тогтоосон тэтгэврийн зэрүүг багасгах талаар Засгийн газарт санал оруулна. 6.8.2. Өндөр насны тэтгэврийн доод хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоож байх, утлаар хөдөлмөрийн, хөлсний доод хэмжээнд хүргэх талаар Засгийн газарт санал оруулна. 6.8.3. Ерөнхийлөгчийн дэргэд, ахмад настны асуудлаар орон тооны бус зөвлөл ажиллуулна. 6.8.4. Дайнд оролцсон ахмад дайчдын тэтгэмжийн доод хэмжээг нэмэгдүүлэх талаар Засгийн газарт санал оруулна. 6.8.5. Цэргийн тэтгэвэрт гарсан ахмадуудын нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх саналыг холбогдох байгууллагад хүрүүлнэ. 6.8.6. "Ахмад настны эрүүл мэнд" сэдвээр Эрүүл мэндийн сайдын мэдээллийг сонсож, цаашид авч хөргөжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газарт санал оруулна. 6.8.7. Аймгийн болон бүсийн төвүүдэд ахмад настанд зориулсан нөхөн сэргээх, эсрэн сувилах газруудыг байгуулах Засгийн газар болон орон нутгийн байгууллагын санал, санаачилгыг дэмжиж ажиллана. 6.8.8. Билгийн улирлын хаврын тэргүүн сар - Цагаан сарыг тохиолдуулан 100 ба түүнээс дээш насны ахмад настанд Ерөнхийлөгчийн гарын болж, 95-99 насны ахмад настанд Ерөнхийлөгчийн мэндчилгээг жил бүр гардуулна.	2005-2006 2005-2007 он 2005 2006 2005-2006 Жил бүр Жил бүр 2005-2009	ЕТГ НХХЯ ЕТГ ЕТГ БХЯ ЕТГ Аймаг, нийслэлийн ЗДТГ ЕТГ НХХЯ ЕТГ ЕТГ
6.9	Нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах талаар чармайлт гаргана.	6.9.1. Жендерийн асуудлаархи олон улсын гэрээ хэлэлцээр болон Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж холбогдох санал санаачилга гаргана. 6.9.2. Жендерийн асуудлаархи ТББ-лын санал санаачилгыг дэмжиж төрийн бодлого, үйл ажиллагаанд тусгахад анхаарна.	2005-2009 2005-2009	ЕТГ Иргэний нийгмийн байгууллагууд

<p>6.10 Нийгэм улс төрийн амьдралд залуучуудын оролцоог дээшлүүлж, тэдний хүч бололцоог хөгжлийн төлөв дайчлан ажиллахад анхаарна</p>	<p>6.10.1.Залуучууд, оюутны төрийн бус байгууллагуудын санал санаачилгыг дэмжиж холбогдох хууль тогтоомжинд тусуулж хэрэгжүүлэх талаар анхаарна.</p> <p>6.10.2.Залуучуудын өмнө тулгарч байгаа асуудлаар судалгаа дүншилт гаргаж, зогсох асуудлыг шийдвэрлэхэд төрийн бус төрийн бус байгууллагуудын анхаарлыг чиглүүлнэ.</p> <p>6.10.3.Залуу гэр бүлийг дэмжих талаархи санал санаачилгыг дэмжиж ажиллана.</p> <p>6.10.4.Өндөр хөгжилтэй орнуудад залуучуудыг боловсрол эзэмшэхэд дэмжлэх үзүүлнэ.</p> <p>6.10.5.Хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр залуучуудын зүгээс гаргаж байгаа санал санаачилгыг дэмжиж ажиллана.</p>	<p>2005-2009</p> <p>2005-2009</p> <p>2005-2009</p> <p>2005-2009</p> <p>2005-2009</p>	<p>ЕТГ, залуучууд оюутны байгууллагууд</p> <p>ЕТГ, ШУ-ны болон залуучуудын байгууллагууд</p> <p>ЕТГ, Засгийн газар</p> <p>ЕТГ, холбогдох яамд</p> <p>ЕТГ, Засгийн газар ТББ</p>
<p>Долоо.Ардчилсан засаглал, нутгийн өөрөө удирдах бусг бажуулж, эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх</p>			
<p>7.1 Иргэд сонгогчиддоо ил тод мэдээлж тайлагнадаг, харилцан харилцлага хүлээж, хяналт тавьдаг ардчилсан засаглалыг бэхжүүлэх хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих бодлого баримтлана.</p>	<p>7.1.1.Ардчилсан засаглалыг бэхжүүлэх талаар Улсын Их Хуралтай хамтран ажиллаж, Засгийн газарт чиглэл өгнө.</p> <p>7.1.2.Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын Ү бага хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинэилгээ хийж, санал чиглэл өгнө.</p> <p>7.1.3.Иргэд, сонгогчдын санал, мэдээлэл, зэрлэг хүсэлтийг судлах, "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл томдлыг шийдвэрлэх тухай" хуулийн хэрэгжилтэй танилцаж шаардлагатай бол боловсронгуй болгох арга хэмжээ авна.</p> <p>7.1.4.Хууль, тогтоомж, төр, засгийн шийдвэр гарахаас өмнө төслийг нь олон түмэнд урьдчилан танилцуулж, шаардлагатай бол санал авч тусгадаг тогтолцоог бий болгоно.</p>	<p>2005-2009</p> <p>2006-2009</p> <p>2006</p> <p>2006-2009</p>	<p>ЕТГ</p> <p>ЕТГ</p> <p>ЕТГ</p>

7.2	Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослох Үндсэн хуулийн үзэл бэрмглэлийн хүрээнд өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, иргэний нийгмийн болон иргэдийн оролцоог дэмжинэ.	7.2.1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн зөвлөлгөөн хийлгэнэ. 7.2.2. Иргэний нийгмийн байгууллагуудын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулна.	2006 2007	ЕТГ ЕТГ
7.3	Төрийн албыг мэргэжлүүлэх, чадваржуулах үндэс төрийн албан хаагчдын сонгон шалгаруулах тогтолцоог төгөлдөржүүлж, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулна.	7.3.1. Төрийн албаны шинэчлэл хийх талаар Засгийн газарт чиглэл өгнө. 7.3.2. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр "Төрийн албаны тухай хууль" нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна. 7.3.3. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны асуудлыг төрийн албаны шинэчлэлттэй холбон шийдвэрлэх талаар Засгийн газарт санал оруулна.	2006-2007 2006-2007 2006-2007	ЕТГ ТАЗ ЕТГ, Засгийн газар ТАЗ ЕТГ, Засгийн газар ТАЗ
7.4	Шүүх эрх мэдлийн байгууллага, шүүгчдийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, тэдний хүртээмжтэй, шударга мэдээмжтэй ажиллах нөхцлийг бүрдүүлж, шүүгчийн ёс зүйн байдалд хяналт тавих, эерчллийг илрүүлж арилгах тогтолцоог бэхжүүлж, боловсронгуй болгоно.	7.4.1. Шүүхийн тухай прокурорын байгууллагын тухай хуулиудад болон холбогдох бусад дүрэм, заавар, журамд нэмэлт, өөрчлөлт оруулна. 7.4.2. Шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн зөвлөлгөөнийг зохион байгуулна.	2005-2006 2008 2005-2009	ЕТГ ХЗДХЯ УДШ УПЕГ ЕТГ
7.5	Анхан шатны шүүгчийг ард түмний шууд сонголтоор шүүгчдийн дундаас сонгон шалгаруулдаг шүүхийн шударга тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.	7.5.1. Энэ асуудлыг судлах ажлын хэсэг байгуулан ажиллуулах, санал болгох. 7.5.2. Шүүгчийг томилж, чөлөөлөх, огцруулах, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх, салган ажиллуулах зарлиг гаргана.	2005-2006 Жил бүр	ЕТГ ЕТГ ШЕЗ
7.6	Гэмт явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй иж бүрэн механизм бүрдүүлэх чиглэлээр засаг, төрийн болон төрийн бус байгууллагуудын бодлого, үйл ажиллагааг дэмжиж амилгана.	7.6.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, мэдээлэл сонсоно. 7.6.2. Гэмт хэргийн нөхцөл байдалд мэргэжлийн байгууллагаар судалгаа дүншилт хийлгэнэ. 7.6.3. Малын хулгайтай тэмцэх механизмыг боловсронгуй болгох санал, санаачилгыг дэмжинэ.	2005-2006 2006 2005-2009	ЕТГ ЕТГ ХЗДХЯ

7.7	Нийгмийн дэг журмыг бэхжүүлж, самилга, харууцлагыг сайжруулах, авилга, архидалт зэрэг нийгмийн гаж үзэгдэлтэй хуулийн хүрээнд эвлэршгүй тэмцэнэ.	7.7.1. Хууль, хяналтлан байгууллагын улдаа холбоог сайжруулах замаар гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ. 7.7.2. Архидан согтуурхтай тэмцэх болон холбогдох бусад хуулуудын хэрэгжилтийн байдалтай танилцаж, зөвлөмж чиглэл өгнө. 7.7.3. Авилгын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай мэдээлэл сонсож хууль эрх зүй орчинг боловсронгуй болгох авилга хээл хахуультай тэмцэх ажлыг эрчимжүүлж хяналт тавьж ажиллана.	2005-2009	2005-2009	2005-2009	2005-2009	ЕТГ ХЭДХЯ
7.8	Нийгмийг удирдах үйл явцад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн эрхсийн орчныг сайжруулах чиглэлээр санаачилгатай ажиллана.	7.8.1. Төрийн бодлогын зарим асуудлаар хууль, шийдвэр гаргахад төрийн бус байгууллагын санал санаачилга, оролцоог хангаж ажиллана.	2005-2009	2005-2009	2005-2009	2005-2009	ЕТГ ХЭДХЯ
Найм. Гадаад харилцааг хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах.							
8.1	Монгол Улсын гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалан үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн Монгол Улсын аюулгүй байдал, толгвортой хөгжилд туслахад гэдвэд орчин бүрэлдэхэд чиглэсэн олон тулгуурт, нээлттэй, бие даасан, идэвхтэй гадаад бодлого явуулна.	8.1.1. Гадаад бодлогын үзэл баримтлалын хэрэгжилтийн талаар танилцуулга мэдээллийг сонсож зөвлөмж, чиглэл өгнө. 8.1.2. Дипломат албаны хууль ба бусад хууль дүрмүүдэд өөрчлөлт оруулах, санал боловсруулна. 8.1.3. Гадаад харилцааны талаархи Ерөнхийлөгчийн Бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллана.	2005	2006	2005-2009	2006-2009	ЕТГ ГХЯ
8.2	Даяаршлын үйл явц, олон улсын харилцааны өнөөгийн байдал, улс орны нийгмийн амьдралд гарсан өөрчлөлтөд нийцүүлэн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулна.	8.2.1. УАБ-ын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулна.	2006	2006	2006	2006	ЕТГ УАБЗ-ийн ажлын алба

8.3	Аюулгүй байдлын шинэ орчин, улс орны бусчилсан хөгжлийн бодлогод нийцүүлэн орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцоог хөгжүүлнэ.	8.3.1. Батлан хамгаалахын удирдах ажилтны улсын зөвлөлгөөн-ийг нээл дороо зохион байгуулах, орон нутгийн хамгаалалтын үзэл баримтлалыг эцэслэн боловсруулахад дамжлаг үзүүлнэ. 8.3.2. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэхтэй уялдуулан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл санаачлах шаардлагатай нөхцөлд Засгийн газарт чиглэл өгнө.	2005	ЕТГ БХЯ
		8.3.3. Улсын хил хамгаалах дүрэм заавруудыг шинэчилж мөрдүүлнэ.	2006-2008	ЕТГ ХХЕГ
		8.3.4. Орон нутгийн хамгаалалтын тогтолцооны бүрдэлт, төлөвшилтөнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт Хүчний Ерөнхий Командлагчийн нэрэмжит үзлэг явуулна.	2006	ЕТГ БХЯ
8.4	Төрийн цэргийн бодлогын дагуу зэвсэгт хүчний шинэчлэлийг гүнзгийрүүлж, цэргийн анги, салбаруудыг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд болтган оролцуулна.	8.4.1. Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс баримт бичгийн хэрэгжилт, Зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх бэлтгэл, чадварт хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажиллана. 8.4.2. Зэвсэгт хүчний стратегийн төлөвлөлтийн зарим баримт бичгийг шинэчлэн батална. 8.4.3. Зэвсэгт хүчин тайван цагт хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх бэлтгэлжилтийн түвшин, боломжид үнэлгээ, дүгнэлт хийнэ.	2005-2009	ЕТГ ЕТГ ЗХЖШ ЕТГ ЗХЖШ

ЕТГ БХЯ ЗХЖШ	2006-2009	8.4.4. Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Засгийн газарт чиглэл өгч, хэрэгжүүлнэ. 8.4.5. Цэргийн цолны нэр хүндийг дээшлүүлэх арга хэмжээ авна /хууль санаачлах, холбогдох журамд бүрэн эрхийнхээ хүрээнд өөрчлөлт оруулах/. 8.4.6. Цэргийн албыг гэрээгээр болон дүйцүүлэх хэлбэрээр хаах тогтолцоог боловсронгуй болгоно /хууль санаачлах/. 8.4.7 Цэргийн албан хаагчдын бүх талын хөгжлийг хангах ауй, орчин цэргийн анги, салбарт бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ /ажил байдалтай тэнцлэх, үүрэг чиглэл өгөх/. 8.4.8. Энхийг сахиулах ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчний чадавхийг дээшлүүлэх. 8.4.9. Цэргийн гадаад харилцааг өргөжүүлж бэхжүүлэх, цэргийн хэргийн хөгжилтэй гадаад оронд боловсон хүчний бэлтгэх, Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийг Монгол Улсад энхийг сахиулах хүчний олон улсын сургалтын төв болгон тохижуулах ажилд дэмжлэг үзүүлнэ.	ЕТГ БХЯ
ЕТГ	2007-2008		ЕТГ БХЯ
ЕТГ БХЯ	2006		ЕТГ БХЯ
ЕТГ БХЯ	2005-2006		ЕТГ БХЯ
ЕТГ	2005-2006		ЕТГ БХЯ
ЕТГ БХЯ	2005-2009		ЕТГ БХЯ
ЕТГ БХЯ	2005-2008	8.5.1. Террорист халдлагын үед Үүрэг гүйцэтгэх томилгоот анги, салбарын сургалт, бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх, зэвсэглэл техникийг шинэчлэх, бие бүрэлдэхүүнийг шаардлагатай агсамжаар хангах талаар Засгийн газарт чиглэл өгнө.	ЕТГ БХЯ
ЕТГ БХЯ	2005-2009	8.5.2. Терроризмоос сэрэмжлэх талаар мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий "Зохицуулах зөвлөл"-ийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүнгийн мэдээллийг хагас жил тутам сонсож, үүрэг чиглэл өгнө.	ЕТГ, ҮАБЗ-ийн ажлын алба

8.6	Гадаад оронд сурч, ажиллаж байгаа Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.	8.6.1. Гадаад оронд ажиллаж буй монгол иргэдийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар БНСУ, ХБНГУ, АНУ зэрэг улстай холбогдох түвшинд хэлэлцээ хийх ажлыг санаачилж эхлүүлнэ. 8.6.2. Албан ёсоор гадаадад сурч, ажиллах боломжийг нэмэгдүүлэх талаар гадаад орнуудад буй дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан тодорхой судалгаа хийж, дүнг Засгийн газраар хэлэлцүүлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл өгнө.	2006-2007	ЕТГ, ГХЯ, НХХЯ
			2006	ЕТГ, ГХЯ, НХХЯ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 267497
Хэвлэлийн хуудас 2.5